



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/12/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.4.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага	10
3.5.4 Бараа материал.....	11
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	11
3.5.7 Өр төлбөр.....	12
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 01/240
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянжаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 20-ны 07 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 8 зорилт 148 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 92.0%-тай буюу "Бүрэн хэрэгжсэн" гэж дүгнэсэн байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын түүхт 100 жилийн ойн хандив тусламжийн эх үүсвэрийг 2022 оны 12 сарын 20-ны сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн 100 жилийн ойн арга хэмжээнд зарцуулахаар 5 аж ахуй нэгж байгууллага, 31 төгсөлтийн хамт олон, 143 иргэн 197,823.0 мянган төгрөгийн мөнгөн хандивыг сумын Орон нутаг хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлэн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж тушаал шийдвэр, гэрээ хийж зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Төв аймгийн Баянжаргалан сум тайлант онд 100 жилийн ойг угтан гудамж хорооллын гэрэлтүүлэг, наадмын талбайн засвар, ёслол хүндэтгэлийн өргөө, морь гарааны төхөөрөмж, соёлын төвд тоног төхөөрөмж, сумын хөшөө дурсгалын өндөрлөг засаж сэргээн засварлах, цагдаагийн кубон засварлах, зам засвар тохижилтын ажилд нийт 296,264.2 мянган төгрөгөөр бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		730,003.0	911,425.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	318,214.4	331,109.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	248,740.7	318,670.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	163,047.9	261,646.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,038,520.8	1,128,819.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,038,520.8	1,128,819.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,768,523.8	2,040,244.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	21,967.5	17,818.6
51	Засгийн газрын хувь оролцоо		1,746,556.3	2,022,425.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,768,523.8	2,040,244.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,085,335.7	1,937,644.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	207,293.7	215,618.4
110	Орлогын албан татвар	133,988.2	150,680.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	148,048.7	166,680.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,060.5	-16,000.0
113	Хөрөнгийн албан татвар	44,955.0	47,338.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	28,350.5	17,599.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	447,007.4	614,814.2
120	Нийтлэг татварын бус орлого	447,007.4	416,991.2
122	Тусламжийн орлого	0.0	197,823.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,431,034.6	1,107,212.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,528,731.6	1,101,789.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,528,731.6	1,101,789.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	831,193.7	1,079,582.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,470.5	474,667.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,165.2	54,861.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,073.8	37,476.4
2104	Хангамж, бараа материалын зардал	37,438.0	102,238.7
2105	Нормативт зардал	9,149.8	26,623.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,632.8	1,601.0
2107	Томилолт, зочны зардал	5,517.5	5,668.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,451.7	7,077.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,294.4	369,368.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	697,537.8	22,207.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	556,604.1	835,854.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,479,571.4	565,667.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,922,967.3	270,187.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,840,544.1	1,690,154.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	207,293.7	215,618.4
110	Орлогын албан татвар	133,988.2	150,680.9

1100	Хувь хүний орлогын албан татвар	148,048.7	166,680.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-14,060.5	-16,000.0
113	Хөрөнгийн албан татвар	44,955.0	47,338.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	28,350.5	17,599.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,713.6	3,073.6
1181	Газрын төлбөр	24,636.9	13,925.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	600.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	202,215.8	367,324.2
120	Нийтлэг татварын бус орлого	202,215.8	169,501.2
122	Тусламжийн орлого	0.0	197,823.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,431,034.6	1,107,212.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,385,934.5	964,806.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,385,934.5	964,806.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	683,501.7	941,109.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,212.2	480,139.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,423.5	54,631.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,107.2	37,872.4
2104	Хангамж, бараа материалын зардал	20,010.9	24,803.4
2105	Нормативт зардал	51,683.9	73,011.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,132.8	3,000.0
2107	Томилолт, зочны зардал	5,517.5	5,668.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,822.9	24,972.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,590.8	237,009.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	702,432.8	23,697.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	454,609.6	725,347.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	258,487.4	621,046.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	258,487.4	621,046.3
2200	Дотоод эх үүсвэрээр	258,487.4	621,046.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-258,487.4	-621,046.3
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-120,999.9	-91,407.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,999.9	91,407.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	75,122.4	12,894.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	243,092.0	318,214.4
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	318,214.4	331,109.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,694,609.4	3,694,609.4
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,746,556.3	1,746,556.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,669,523.6	3,669,523.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-25,085.8	-25,085.8
9	Тайлант үеийн үр дүн	-1,922,967.3	-1,922,967.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,746,556.3	1,746,556.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,682.3	5,682.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,752,238.6	1,752,238.6
19	Тайлант үеийн үр дүн	270,187.3	270,187.3
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,022,425.9	2,022,425.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,435,832.7	1,300,732.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	950,968.8	794,405.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	932,860.6	776,297.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	441,538.1	438,872.5
210101	Үндсэн цалин	370,165.2	331,526.9

210102	Нэмэгдэл	63,841.1	93,091.2
210104	Урамшуулал	7,531.8	14,254.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,192.1	50,157.7
210201	Тэтгэврийн даатгал	37,530.7	35,527.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,415.4	3,587.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,532.3	3,124.7
210204	Ажилгүйдлийн даатгал	883.1	711.6
210205	Эрүүл мэндийн даатгал	8,830.6	7,205.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	367,290.0	223,012.9
210301	Гэрэл, цахилгаан	36,846.4	19,204.3
210302	Түлш, халаалт	326,886.8	203,376.1
210303	Цэвэр, бохир ус	3,556.8	432.5
2104	Хангамж, бараа материалын зардал	26,595.8	24,428.4
210401	Бичиг хэрэг	2,247.9	2,244.6
210402	Тээвэр, шатахуун	18,067.9	18,045.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,680.0	2,054.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,500.0	1,983.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,150.0	8,150.0
210604	Урсгал засвар	9,150.0	8,150.0
2107	Томилолт, зочны зардал	5,999.4	5,668.6
210702	Дотоод албан томилолт	5,999.4	5,668.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,595.2	15,940.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,220.0	15,220.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	200.0	200.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300.0	300.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	227.2	220.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,500.0	10,067.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000.0	6,992.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500.0	3,075.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,108.2	18,108.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,108.2	18,108.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,108.2	15,108.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000.0	3,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,364,863.9	414,920.3
220001	Барилга байгууламж	183,767.3	172,923.2
221001	Их засвар	135,276.2	94,558.9
222001	Тоног төхөөрөмж	102,056.4	102,006.5
223001	Бусад хөрөнгө	943,764.0	45,431.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000.0	91,407.0
230001	Эргэж төлөгдөх зээл	120,000.0	91,407.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,435,832.7	1,278,812.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	352,874.8	344,041.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	352,874.8	344,041.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,005,968.8	856,305.0
320001	Орон нутгийн төсвөөс	1,005,968.8	856,305.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	276,989.1	78,466.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000.0	78,466.4
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	156,989.1	0.0
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	800,000.0	0.0
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	800,000.0	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	182,062.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	160,141.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	54	54
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9

650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6
--------	-----------------------------	---	---

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,158.49	92,196.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,158.49	92,196.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,129.99	86,067.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	40,505.34
210101	Үндсэн цалин	0	4,187.91
210102	Нэмэгдэл	0	36,317.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	4,473.27
210201	Тэтгэврийн даатгал	0	3,461.37
210202	Тэтгэмжийн даатгал	0	221.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	357.17
210204	Ажилгүйдлийн даатгал	0	44.28
210205	Эрүүл мэндийн даатгал	0	389.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,482.57	0
210303	Цэвэр, бохир ус	3,482.57	0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,383.49	375.00
210402	Тээвэр, шатахуун	1,383.49	375.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.00	605.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300.00	605.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,963.93	40,109.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,859.93	40,109.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,028.50	6,128.66
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,028.50	6,128.66
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	12,028.50	0
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	917.56
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	5,211.10
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51,158.49	92,196.32
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,158.49	92,196.32
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,000.00	0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,327.61	52,777.01
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,830.88	39,419.31

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Нийгмийн хариуцлагын гэрээгээр Эм би эм эксплорейшн ХХК Төв аймгийн Баянжаргалан сумын Түүхт 100 жилийн ойн баяр наадмын бичлэг хийж, шууд дамжуулалтыг гүйцэтгэсэн ба Графит пит майнинг ХХК 5 настай улиас мод 500 ширхэг, чацаргана 500 ширхэг, Цинзури ХХК 20,000.0 мянган төгрөг, Эрдэнэ майнинг үйлс ХХК 3 ширхэг эко нойл, сумын төвийн хашааны эвдэрсэн хэсгийг сэлбэн засах, гэрэлтүүлгийг засварлах зэрэг 20,000.0 мянган төгрөгийн ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 20-ны 07 дугаар тогтоолоор сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 8 зорилт 148 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 92.0%-тай буюу “Бүрэн хэрэгжсэн” гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянжаргалан сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын дотоод хяналтын баг нь 2023 онд хийж хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөөгүй бөгөөд дотоод хяналт хийж гүйцэтгээгүй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Аймгийн Засаг даргын захирамжаар 2021 оны 03 сард баталсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,040,244.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 271,720.7 мянган төгрөгөөр буюу 13,3 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31	Өсөлт (+), Бууралт (-)
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	318,214.4	331,109.0	12,894.6
33	АВЛАГА	248,740.7	318,670.2	69,929.5
35	БАРАА МАТЕРИАЛ	163,047.9	261,646.1	98,598.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,038,520.8	1,128,819.3	90,298.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,768,523.8	2,040,244.5	271,720.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,967.5	17,818.6	-4,148.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	723,048.4	723,048.4	0.0
51200	Хуримтлагдсан үр дүн	792,951.7	1,068,821.3	275,869.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,556.2	230,556.2	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,768,523.8	2,040,244.5	271,720.7

Эх сурвалж: Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 331,109.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,894.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 318,670.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 69,929.5 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага 50,068.0 мянган төгрөг болж 32,500.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 251,916.9 мянган төгрөг болж 24,365.8 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 261,646.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 98,598.2 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын бараа материал 238,292.3 мянган төгрөг болж 95,808.9 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,128,819.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 90,298.5 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгө 1,120,709.2 мянган төгрөг болж 84,095.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Эмийн эргэлтийн сангийн үндсэн хөрөнгө 4,450.0 мянган төгрөг болж 4,303.3 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 331,108.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 12,894.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	318,214.4	331,108.9	12,894.6
Төгрөг	318,214.4	331,108.9	12,894.6
Төрийн сангийн харилцах	269,975.5	282,915.6	12,940.1
Арилжааны банк дахь харилцах	48,238.9	48,193.3	-45.5

Эх сурвалж: Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 282,915.6 мянган төгрөгийн 33,9 хувь буюу 95,798.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 35,7 хувь буюу 101,060.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 20,9 хувь буюу 59,081.8 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 9,5 хувь буюу 26,975.1 мянган төгрөгийг Байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 12,894.6 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн ерөнхий орлогын 34,860.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

1. Баянжаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шийдвэргүйгээр төрийн албаны улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 2,525.3 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 318,670.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 69,929.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
АВЛАГА ДҮН	248,740.7	318,670.2	69,929.5
Байгууллагаас авах авлага	18,919.6	51,438.5	32,518.9
Хувь хүмүүсээс авах авлага	229,821.1	267,231.7	37,410.6

Эх сурвалж: Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 318,670.2 мянган төгрөгийн 83,9 хувийг буюу 267,231.7 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 94,3 хувь буюу 251,916.9 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

Аудитын илрүүлэлт

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайланд Эмийн эргэлтийн сангийн 9,221.6 мянган төгрөгийн авлага, Хоршоо хөгжүүлэх сангийн 251,916.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлээгүй гэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 261,646.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 98,598.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	0	395.0	395.0
Эм боох материал	15,829.4	18,244.1	2,414.7
Бичиг хэргийн материал	3,562.1	40,158.2	36,596.1
Аж ахуйн материал	20,713.0	47,735.1	27,022.2
Сэлбэг хэрэгсэл	114,268.2	114,268.2	0.0
Түлш, шатах тослох материал	0.0	1,188.8	1,188.8
Бусад хангамжийн материал	6,805.2	37,786.7	30,981.5
Мал амьтад	1,870.0	1,870.0	0.0
Дүн	163,047.9	261,646.1	98,598.2

Эх сурвалж: Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 261,646.1 мянган төгрөгийн 91,1 хувийг ЗДТГ, 7,0 хувийг эмийн эргэлтийн сан, 1,9 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 98,598.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 156,372.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 1,801,787.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 163,478.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	1,294,877.0	1,470,388.8	175,511.8
Тээврийн хэсэгсэл	154,677.3	74,817.9	-79,859.4
Машин тоног төхөөрөмж	74,446.8	104,119.5	29,672.7
Тавилга эд хогшил	29,206.1	56,559.1	27,353.0
Бусад үндсэн хөрөнгө	0.0	7,800.0	7,800.0
Програм хангамж	1,080.0	4,080.0	3,000.0

Бусад биет бус хөрөнгө	84,022.0	84,022.0	0.0
Дүн	1,638,309.2	1,801,787.4	163,478.1

Эх сурвалж: Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 1,801,787.4 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,1 хувь буюу 1,784,801.9 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,5 хувь буюу 8,119.2 мянган төгрөгийг ИТХ, 0,5 хувь буюу 8,866.3 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 163,478.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 228,811.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 29,525.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөрийн эцсийн үлдэгдэл 17,818.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,148.9 мянган төгрөгөөр хорогдсон байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	21,967.5	17,818.6	-4,148.9
Байгууллагад төлөх өглөг	21,967.5	17,818.6	-4,148.9

Эх сурвалж: Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн жилийн эцсийн 17,818.6 мянган төгрөгийн үлдэгдлийн 71,7 хувь буюу 12,768.6 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн өглөг, 2,2 хувь буюу 400.0 мянган төгрөгийг ЗДТГ-ын өглөг, 26,1 хувь буюу 4,650.0 мянган төгрөгийг Байгаль хамгаалах сангийн өглөг эзэлж байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,022,425.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 275,869.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	723,048.4	723,048.4	0.0
Дахин үнэлгээний нөөц	230,556.2	230,556.2	0.0
Хуримтлагдсан дүн	792,951.7	1,068,821.3	275,869.6
Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	1,746,556.3	2,022,425.9	275,869.6

Эх сурвалж: Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 275,869.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баянжаргалан сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Сумын 2023 оны төсөв батлах тухай" 01 дүгээр тогтоолоор 2023 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба

татварын бус орлогыг 214,579.0 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 2,128,527.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Баянжаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолд зааснаар Баянжаргалан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 231,036.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж, гүйцэтгэлээр 219,484.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 95,0 хувиар биелүүлсэн байна. Татварын 7 нэр төрлийн орлого тасарсан байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 43,122.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 532,417.4 мянган төгрөгөөр, ИТХ-ын үйл ажиллагааны зардлыг 3,642.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 105,517.2 мянган төгрөгөөр, Хөрөнгийн зардлыг 48,610.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,342,914.6 мянган төгрөгөөр тодотгон, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөнд 16,457.5 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөөнд 23,358.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөөнд 48,610.6 мянган төгрөг, сумын шилжих үлдэгдэл 6,949.3 мянган төгрөгөөр өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 231,036.5 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 683,003.2 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 352,874.8 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 6,949.3 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 75,328.2 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын шилжих үлдэгдлээс 74,711.6 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд 100 жилийн ойн хандив, тусламжийн эх үүсвэр 800,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,684,167.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 185,612.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,498,555.8 мянган төгрөг буюу 89,0 хувьтай байгаа Хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 59,081.8 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 590,843.9 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын 8 хөтөлбөрийн 23 арга хэмжээнд 2,223,903.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас, гүйцэтгэлээр 1,684,167.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
№	Хөтөлбөр	Зарцуулах төсөв	Зарцуулсан	Зөрүү	Биелэлт
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	105,517.2	103,911.5	1,605.7	98.5%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	532,417.4	521,706.9	10,710.5	98.0%
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	150,488.8	91,407.0	59,081.8	60.7%
4	71802-Ерөнхий боловсролын сургууль	111,888.6	108,615.5	3,273.1	97.1%
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол	45,964.6	37,956.3	8,008.3	82.6%
6	71702-Соёлын үйлчилгээ	12,416.1	12,416.1	-	100%
7	71602-Эрүүл мэндийн төв	33,571.4	31,698.6	1,872.8	94.4%
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	691,903.8	590,843.9	101,060.0	85.4%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 80,137.2 мянган төгрөг, ИТХ 12,059.1 мянган төгрөг, нийт 92,196.3 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн 23 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан	Хувь
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, хуралдааныг зохион байгуулж, шаардлагатай мэдээллээр тасралтгүй хангахад оршино. Жилд 5-аас доошгүй удаа хурал хийнэ.	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааныг зохион байгуулж жилд 6 ээлжит 4, ээлжит бус 2удаа хуралдсан байна. Хэрэгжилт 100%	105,517.2	103,911.5	98%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 8 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 98.5%	532,417.4	521,706.9	98%
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	2023 оны 1 сараас Сум хөгжүүлэх санг шинээр Хоршоо хөгжүүлэх сан болгон журмыг дагаж мөрдөх. Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох	2023 онд Хоршоо хөгжүүлэх сангаас оны эхний хагас жилд 12 иргэний төсөл хүлээн авч 10 иргэнд 90 сая төгрөгийн зээлийг олгохоор шийдвэр гарсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 90 %	150,488.8	91,407.0	61%
4	71802- Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	Ерөнхий боловсрол сургууль нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	өр авлага үүсээгүй батлагдсан төсвийн дагуу зорилт, арга хэмжээ хэрэгжсэн Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	111,888.6	108,615.5	97%
5	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	Сургуулийн өмнөх боловсрол нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	Өр авлага үүсээгүй батлагдсан төсвийн дагуу зорилт, арга хэмжээ хэрэгжсэн Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	45,964.6	37,956.3	83%
6	71702- Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёлын төв нь 1 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	өр авлага үүсээгүй батлагдсан төсвийн дагуу зорилт, арга хэмжээ хэрэгжсэн Хөтөлбөрийн хэрэгжилт 100%	12,416.1	12,416.1	100%
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	Эрүүл мэнд төв нь 2 зорилт 3 арга хэмжээ хэрэгжүүлэх	өр авлага үүсээгүй батлагдсан төсвийн дагуу зорилт, арга хэмжээ хэрэгжсэн	33,571.4	31,698.6	94%

				Хөтөлбөрийн хэрэгжилт 100%			
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийт он дамжин хийгдэх 9 төсөл, шинээр хэрэгжих 14 төслийг 3 1,342,914.600 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэнэ.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 14, хэрэгжээгүй 9 хөрөнгө оруулалтын ажил, хэрэгжилт 70.8%	691,903.8	590,843.9	85%

Баянжаргалан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 33 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар 1,511,198.6 мянган төгрөгөөр баталсан ба тайлант онд тодотгол хийж 38 бараа, ажил үйлчилгээг 1,215,755.9 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

21 бараа, ажил үйлчилгээг 213,049.2 мянган төгрөгөөр Баясгалант төв ХХК, Ивээлт ганга болор ХХК, Мейд буян трейд ХХК, Г.Эхлэнбаатар, Ц.Давааням, Ч.Отгонбат нараас шууд худалдан авалт хийсэн байна.

218,885.2 мянган төгрөгийн тээвэр шатахуун, хоол хүнс, үдийн цайны материал нийлүүлэх, гамшгийн хашаа барих, мал угаалын ванн барих 5 багц худалдан авалтыг тендер шалгаруулалтын онцгой журмаар зарласан бөгөөд Ник ХХК, Баясгалант төв ХХК, Нандиншигтгээ ХХК, Жаргалант ТАБС ХХК шалгаран гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 229,264.2 мянган төгрөгөөр 4 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт болон тендер шалгаруулалтын онцгой журмаар худалдан авахаар төлөвлөсөн байна. Соёлын төвийн тоног төхөөрөмж хувцас нийлүүлэх ажлыг Саннилайф ХХК, нийтийн эзэмшлийн талбай тохижуулах ажлыг Хуст трак ХХК, цагдаагийн кабон засварлах ажлыг ЭЧМ ХХК, Гудамж хорооллын гэрэлтүүлгийн ажлыг Премиум эко ХХК хийж гүйцэтгэхээр тус тус шалгаран хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 05/59 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого 1,401,639.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,024.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 15,768.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянжаргалан сумын төсөвт 5 байгууллага нийт 26,010.0 мянган төгрөгийн зардал хэмнэн ажилласан байна.

Засаг даргын Тамгын газар нь Үндсэн үйл ажиллагааны зардлаас бүтэц орон дутуугаас цалинг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 6,695.2 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлаас 21.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 663.0 мянган төгрөг, томилолтын зардлаас 159.7 мянган төгрөг, шуудан холбооны зардлаас 624.1 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 49.9 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэн байна. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 980.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 1,516.6 мянган төгрөг, нийт 10,710.4 мянган төгрөгийн зардал хэмнэн ажилласан байна.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үндсэн үйл ажиллагааны цалин, урамшуулал нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,004.7 мянган төгрөг, шуудан холбоо, бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 2,179.3 мянган төгрөг, нийт 3,184.0 мянган төгрөгийн зардал хэмнэн ажилласан байна.

Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 13,154.1 мянган төгрөгийн зардлын хэрэглээгээ багасган хэмнэн ажилласан байна.

ОНХС-аас дараа он руу шилжсэн 5 арга хэмжээний зардал мах нядалгааны цех, ногоон байгууламж, мал угаалгын ванн, хогны машин, худаг барих ажлын нийт 101,059.9 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

ХХС-аас зээлийн шалгуур үзүүлэлт хангасан хоршоо байхгүйгээс шалтгаалан 59,081.8 мянган төгрөгийн зардал хэмнэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 168 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 10 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 157,198.6 мянган төгрөгийн 18 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 468,3010.3 мянган төгрөгийн 13 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 1,486,198.6 мянган төгрөгийн 32 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 35 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 05/135 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	1	93,415.0	1	93,415.0	100
Нийт дүн	2	93,415.0	2	93,415.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянжаргалан сумын ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 263,092.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 263,092.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд Төрийн сангийн харилцах дансны татварын орлогын гүйцэтгэлийг 5 нэр төрлөөр аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 1,953.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

2. Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайланд 261,138.5 мянган төгрөгийн авлагын насжилтыг оруулаагүй, тооцоо нийлээгүй гэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6

дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “ангилал”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 22,248.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 22,248.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 95,0 хувиар биелсэн боловч Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар, Галт зэвсгийн албан татвар, Газрын төлбөр, Хог хаягдлын хураамж, Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар, Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого (суутган-3), Газрын дуудлага худалдааны орлого 16-100 хувиар буюу 22,081.6 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

2. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орлогын гүйцэтгэлийн тодруулга тайланд төсвийн орлогын гүйцэтгэлийг 219,651.1 мянган төгрөгөөр, аймгийн Татварын хэлтсийн аудитад ирүүлсэн 2023 оны төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлээс 167.1 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын байцаагчтай орлогын дүнг сар улирлаар тохирч байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	6	1	5			1		

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг дарга	2	263,092.0	1	261,138.5	1	1,953.5	2	263,092.0				
ЗДТГ	4	375,141.3	1	244,973.2	3	130,168.1	4	375,141.3				
ХХС	1	125,836.3	1	125,836.3			1	125,836.3				
ОНХС	1	25,000.0			1	25,000.0	1	25,000.0				
Дүн	8	789,069.6	3	631,948.0	5	157,121.6	8	789,069.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	2	22,248.7					2	22,248.7				
ИТХ	1	2,525.3	1	2,525.3								
ЗДТГ	4	1,773,199.1	1	9,403.6	1	1,756,501.9	2	7,293.7				

